



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2017 оны 02 сарын 03 өдөр

Дугаар 5/27

Хэрлэн сум

Ажлаас чөлөөлж,
түр орлон гүйцэтгэгч томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Боловсролын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1, 30.1.15, 30.1.16, Хөдөлмөрийн тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.1, 38.1.1 дэх заалт Засгийн газрын 2007 оны "Сургуулийн өмнөх болон бага, дунд боловсрол эзэмшүүлэх сургалтын байгууллагын төрийн үйлчилгээний албан тушаалын ангилал, зэрэглэл" батлах тухай 354 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралт, 2014 оны "Төрийн зарим албан хаагчийн цалингийн талаар авах арга хэмжээний тухай" 75 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Дэлгэрхаан сумын ерөнхий боловсролын сургуулийн захирал Ж.Билэгсайхан нь ажлаас чөлөөлөгдөх хүсэлт гаргасан тул 2017 оны 02 дугаар сарын 06-ны өдрөөс эхлэн үүрэгт ажлаас нь чөлөөлж, мөн өдрөөс эхлэн тус сургуулийн багш Ж.Үүрийнтуяаг сургуулийн захирал томилогдох хүртэл түр орлон гүйцэтгэгчээр томилсугай.

Хоёр. Сургуулийн захирлын ажлыг хүлээлцэх комисс томилон хүлээлцүүлэхийг сумын Засаг дарга /О.Анхбат/-д даалгасугай.

Гурав. Ж.Билэгсайхантай зохих хууль, журмын дагуу холбогдох тооцоог хийж дуусган сургуулийн захирлын түр орлон гүйцэтгэгчээр томилогдож байгаа Ж.Үүрийнтуяагийн цалинг ТҮБД-н 7-ын 1 дүгээр шатлал /673849/ төгрөгөөр тогтоож, цалинжуулахыг сургуулийн нягтлан бодогч /Д.Энхсаруул/-д зөвшөөрсүгэй.

Дөрөв. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн бодлогын хэлтэс / Г.Лхагвахатан/-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Н.ГАНБЯМБА